МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
З А Х И Р А М Ж

2018 оны 10 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 166 | Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулахад тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч: -Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин.

Гишүүд:

-Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн;

-Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан;

-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мэргэн;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн;

-Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан;

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор;

-Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин;

-Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал;

-Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү;

-“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл” хэрэгжүүлэх нэгжийн захирал Л.Энхбат;

-Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны албаны дэд дарга Н.Мягмарсүрэн.

Нарийн бичгийн дарга:

-Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мягмарсүрэн.

2. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулахад тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, шаардлагатай асуудлыг тухай бүр Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж ажиллахыг Ажлын хэсэг /Ө.Энхтүвшин/-т даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ